



НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР

ДААТГУУЛАГЧААС ИРҮҮЛСЭН ТЭТГЭМЖ АВАХ ЦАХИМ ХҮСЭЛТИЙГ ХЯНАХ, БОДОЖ ОЛГОХ ЗААВАР

- ◆ Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах хүсэлт
- ◆ Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах хүсэлт
- ◆ Ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлт

Нийгмийн даатгалын ажилтнуудад зориулав.

2022 оны 5-р сар

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах хүсэлт



Албан журмын даатгуулагч:

Алхам 1.

- Эрүүл мэндийн байгууллагаас албан журмын даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудсыг цахимаар бичиж **ажил олгогчид илгээнэ**.
- Ажил олгогчоос даатгуулагчийн тэтгэмж авах хүсэлтийг Нийгмийн даатгалын байгууллагад гаргана.

Алхам 2.

- Ажил олгогчийн “Шимтгэлийн цахим систем (НД-8)”-ийн **“эмнэлгийн хуудас”** цэсэнд даатгуулагчийн цахимаар бичүүлсэн эмнэлгийн хуудасны жагсаалт **“эмнэлгээс ирүүлсэн”** төлөвтэй харагдана. Ажил олгогчоос **“ХЧГА”** хэсгийг дарж даатгуулагчийн сүүлийн бүтэн ажилласан 3 сар (дараалсан 3 сар байх шаардлагагүй)-ыг сонгоно.

Сайн дурын даатгуулагч:

- Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагч эмнэлгийн хуудсаа цахимаар бичүүлж, тэтгэмж авах хүсэлтээ **daatguulagech.mn** эсвэл **e-mongolia.mn** веб, **e-mongolia** аппликейшний тусламжтайгаар Нийгмийн даатгалын байгууллагад гаргана.
- Даатгуулагч **“хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж”**-ийг сонгож эмнэлгийн хуудасны ард байрлах **“хүсэлт гаргах”** товчийг дарж өргөдлийн маягтын дагуу мэдээллийг оруулна.

Албан журмын даатгуулагч:

Алхам 3.

- Ажил олгогчоос сонгосон сарыг үндэслэн даатгуулагчийн тэтгэмжийн тооцооллыг програмаас автоматаар харуулах бөгөөд ажил олгогч тэтгэмж бодолтыг нягтлан шалгасны дараа хүсэлтийг Нийгмийн даатгалын байгууллагад илгээнэ.
- Ажил олгогчоос сүүлийн бүтэн ажилласан 3 сарыг сонгоогүй, мөн сонгон цалин нь “0” бол илгээх товч гарахгүй.

Алхам 4.

- Ажил олгогчоос даатгуулагчийн тэтгэмжийн мэдээлэл нийгмийн даатгалын байгууллагад амжилттай илгээгдсэн тохиолдолд “НД-руу илгээсэн” төлөвт шилжин.

Алхам 5.


- Нийгмийн даатгалын байгууллагаас тэтгэмж бодогдсон бол ажил олгогч даатгуулагчийн жагсаалтыг Б-НД-2.1 маягтаар болон тэтгэмжийн нэхэмжлэхээ хэвлэн гарын үсгээр баталгаажуулж Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлнэ.

Сайн дурын даатгуулагч:

- Тэтгэмж авах хүсэлтээ баталгаажуулж, “Хүсэлт илгээх” товчийг дарж Нийгмийн даатгалын байгууллагад хүсэлтээ илгээнэ.
- Хүсэлт амжилттай илгээгдсэн бол “хүсэлт илгээгдсэн” төлөвт шилжинэ.


Алхам 6.

Даатгуулагчаас илгээсэн хүсэлтийг Нийгмийн даатгалын байгууллагын магдалагч эмч эмнэлгийн хуудасны бичилт болон үндэслэлийг <http://10.9.0.5/medmonitor/#/account/login> програм ашиглан шалгаад тэтгэмж авах хүсэлтийг батлах эсвэл буцаана.




Алхам 7.

Нийгмийн даатгалын байцаагч тэтгэмжийн програмын “Цахим хүсэлт” цэснээс “ХЧТА” сонгоно.





Алхам 8.

ХЧТА цонхонд эмнэлгийн хуудас, тэтгэмж авах хүсэлт харагдана.




Алхам 9.

Байцаагчаас тэтгэмж авах хүсэлтийн дагуу эмнэлгийн хуудасны үндэслэл, тэтгэмж авах эрх үүссэн эсэхийг хянаж, тэтгэмж авах эрх үүссэн бол тэтгэмжийг бодно.



Алхам 10.

Тэтгэмж авах хүсэлтийг хянаж, тэтгэмж авах эрх үүсэхгүй тохиолдол шалтгааныг сонгон хүсэлтийг буцаана.



Алхам 11.

Нийгмийн даатгалын байгууллагаас тэтгэмжийг шалган баталгаажуулсан бол тэтгэмж авах хүсэлт “тэтгэмж бодогдсон” төлөвт, тэтгэмж бодолтыг буруу эсвэл эмнэлгийн хуудсыг үндэслэлгүй гэж үзсэн тохиолдолд “буцаасан” төлөвт тус тус шилжүүлнэ.


Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах хүсэлт



- Алхам 1.**
- Нийгмийн даатгалд сайн дураар болон албан журмаар даатгуулагч тэтгэмж авах хүсэлтээ эмнэлгийн хуудас бичүүлснээс хойш хуанлийн 28 хоногийн дотор daatguulagch.ndaatgal.mn эсвэл e-mongolia.mn веб, e-mongolia аппликейшний тусламжтайгаар цахимаар гаргана.
- Алхам 2.**
- Даатгуулагч daatguulagch.ndaatgal.mn эсвэл e-mongolia.mn веб, e-mongolia аппликейшнд холбогдох эрхээр нэвтэрнэ.
- Алхам 3.**
- Тэтгэмж хэсгээс “**жирэмсний болон амаржсаны тэтгэмж**”-ийг сонгож “**хүсэлт гаргах**” товчийг дарж өргөдлийн маягтын дагуу утасны дугаар, и-мэйл хаяг, банкны дансны мэдээллийг гараас оруулна.
- Алхам 4.**
- Даатгуулагч тэтгэмж авах хүсэлтээ “**хүсэлт илгээх**” товчийг дарж Нийгмийн даатгалын байгууллагад илгээнэ. Амжилттай илгээгдсэн бол “**хүсэлт илгээгдсэн**” төлөвт шилжинэ.
- Алхам 5.**
- Даатгуулагчаас илгээсэн хүсэлтийг Нийгмийн даатгалын байгууллагын магадлагч эмч эмнэлгийн хуудасны бичилт болон үндэслэлийг <http://10.9.0.5/medmonitor/#/account/login> програм ашиглан шалгаад тэтгэмж авах


Алхам 6.

- Нийгмийн даатгалын байцаагч тэтгэмжийн програмын “Цахим хүсэлт” цэснээс “Жирэмсэн, амаржсан” тэтгэмжийг сонгоно.




Алхам 7.

- “Жирэмсэн, амаржсан” цонхонд эмнэлгийн хуудас, тэтгэмж авах хүсэлт харагдана.




Алхам 8.

- Нийгмийн даатгалын байцаагч тэтгэмж авах хүсэлтийн дагуу эмнэлгийн хуудасны үндэслэл, тэтгэмж авах эрх үүссэн эсэхийг хянаж, тэтгэмж авах эрх үүссэн бол тэтгэмжийг бодно.



Алхам 9.

- Тэтгэмж авах хүсэлтийг хянаж, тэтгэмж авах эрх үүсэхгүй тохиолдолд шалтгааныг сонгон хүсэлтийг буцаана.



Хүсэлт буцаах

Хүсэлт буцаах шалтгаан

Бусад шалтгаан

Эрх үүсээгүй

Бусад шалтгаан

Хадгалах

Болих

Алхам 10.

- Нийгмийн даатгалын байгууллагаас тэтгэмжийг шалган баталгаажуулсан бол тэтгэмж авах хүсэлт “**тэтгэмж бодогдсон**” төлөвт, тэтгэмж бодолтыг буруу эсвэл эмнэлгийн хуудсыг үндэслэлгүй гэж үзсэн тохиолдолд “**буцаасан**” төлөвт тус тус шилжүүлнэ.


Ажилгүйдлийн ТЭТГЭМЖ авах хүсэлт



- Алхам 1.**
- Даатгуулагч ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлтээ цахимаар илгээх тохиолдолд daatguulagch.ndaatgal.mn эсвэл e-mongolia.mn веб, e-mongolia аппликейшний тусламжтайгаар гаргана.
- Алхам 2.**
- daatguulagch.ndaatgal.mn эсвэл e-mongolia.mn веб, e-mongolia аппликейшнд холбогдох эрхээр нэвтэрнэ.
- Алхам 3.**
- Ажилгүйдлийн тэтгэмжийг сонгож “тэтгэмж авах хүсэлт” товч дарж хүсэлт илгээхэд даатгуулагчийн Хөдөлмөрийн байгууллагад бүртгүүлсэн мэдээлэл шалгагдана. Өөрөөр хэлбэл иргэн хөдөлмөр байгууллагад өөрийн биеэр хандаж бүртгүүлсэн талаарх мэдээллийг харуулна.
- Алхам 4.**
- Хэрэв хөдөлмөрийн байгууллагад бүртгэлтэй бол даатгуулагч тэтгэмж авах өргөдлийг бөглөнө. Үүнд:
- Гар утасны дугаар, и-мэйл хаяг
 - Банкны дансны мэдээлэл
 - Ажлаас чөлөөлөгдсөн тушаалыг “зураг” форматаар хавсаргаж, ажлаас чөлөөлөгдсөн огноог гараас оруулна. Шаардлагатай тохиолдолд ажил олгогчтой тооцоо нийлсэн акттай бол акт үйлдсэн огноо болон актыг мөн “зураг” форматаар оруулна.
- Алхам 5.**
- Тэтгэмж авах өргөдлийг цахимаар гаргахыг зөвшөөрсөн тэмдэглэгээ хийн “хүсэлт илгээх” товчийг дарж Нийгмийн даатгалын байгууллагад илгээнэ.


Алхам 5.

- Нийгмийн даатгалын байцаагч тэтгэмжийн програмын “Цахим хүсэлт” цэснээс “Ажилгүйдэл” тэтгэмжийг сонгоно.






Алхам 6.

- “Ажилгүйдэл” цонхонд даатгуулагчийн ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлт харагдана.



Алхам 7.

- Нийгмийн даатгалын байцаагч ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлтийн дагуу эрх үүссэн эсэхийг шалгана.



Алхам 10.

- Нийгмийн даатгалын байцаагч хянаж үзээд эрх үүссэн бол ажилгүйдлийн тэтгэмжийг бодно.

Ажилгүйдлийн даатгалын сан - Ажилгүйдлийн тэтгэмж

Тогтоолт Хадгал Болж Гаргах

Даат-ийн нэр: ЭРДЭНЭСҮВД Эцэг/эхийн нэр: ӨЛЗИЙБАЯР Даат-ийн код: Регистрийн №: И396111000

[Тэтгэмжүүд...]

Огноо

<No data to display>

0

[Тэтгэмжийн мэдээ...]

Ажлаас чөлөөлөгдсөн огноо: 2021.11.28 Огноо: 2021.12.01 11:46:31

Бүртгүүлсэн огноо: 2021.10.18 Эхэлсэн огноо: 2021.10.19

[Тэтгэмж бодолт, олголт...]

Ажлаас халагдсан шалтгаан: Даатгуулагчаас шалтгаалсан

Ажилласан жил: 3 сарын цалин

Тэтгэмж олгох хоног:

Банк: Хаан банк Дансны дугаар: 550664568

Ажилласан жил: 5 хүртэл жил

Бодох хувь: 45

Цалингийн дундаж:

Бодох дундаж:

Бүх олгох:

Сургалт Урьдчилсан төлөлт Жинхэнэ төлөлт

Урьдчилсан төлөлт

Огноо

<No data to display>

0

Урьдчилсан төлөлт

Огноо:

Олгох хоног

Нийт олгох

Алхам 11.

- Тэтгэмж авах эрх үүсэхгүй тохиолдол шалтгааныг сонгон хүсэлтийг буцаана.

Хүсэлт буцаах

Хүсэлт буцаах шалтгаан

Бусад шалтгаан

Эрх үүсээгүй

Бусад шалтгаан

Хадгалах Болж

Алхам 12.

- Нийгмийн даатгалын байгууллагаас тэтгэмж олгох хүсэлтийг шалган баталгаажуулсан бол “тэтгэмж бодогдсон” төлөвт, тэтгэмжийн эрх үүсээгүй тохиолдолд “буцаасан” төлөвт тус тус шилжүүлнэ.



НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР



www.ndaatgal.mn



7777-1289, 1800-0724



[sigomongolia](https://www.facebook.com/sigomongolia)